

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14.7 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР
ДҮНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТОВЧ ТАЙЛАН**

Аудитын код: НАГ-2025/20-ШТА-НА

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ”, 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан ч аймгийн хэмжээнд 5 төсвийн шууд захирагч ахмадын сан байгуулжээ. Аймгийн хэмжээнд нийт 177 төсвийн шууд захирагч байгаагаас 97 хувь буюу 172 байгууллага ахмадын сан байгуулаагүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.



№	Шалгагдагч байгууллагын нэр	2024 оны цалингийн нийт сан	Ахмадын сангийн эхний үлдэгдэл	Ахмадын сангийн орлого	Ахмадын сангийн зарлага	Ахмадын сангийн эцсийн үлдэгдэл
1	Ховд аймаг дахь ШШГГ 457 дугаар нээлттэй хаалттай хорих анги	1,854.2	1.3	4.3	3.0	2.7
2	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	961.2	6.1	-	3.7	2.4
3	Баруун бүс төв Ховд аймгийн Онцгой байдлын газар	5,334.2	0.8	40.9	15.7	26.0
4	Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар	2,016.0	13.0	-	11.7	1.3
5	Ховд аймгийн Цагдаагийн газар	6,887.4	58.1	12.6	26.0	44.7
Нийт дүн		17,053.0	79.3	57.9	60.1	77.1

Аймгийн хэмжээнд ахмадын сангийн дансны эхний үлдэгдэл 79.3 төгрөг байсан бол ахмадын санд нийт 3 байгууллага нь 57.9 сая төгрөгийг төвлөрүүлж Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх, Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар нь дансанд мөнгөн орлого төвлөрүүлээгүй байна.

Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар нь 2024 онд арилжааны банкны хүүгийн орлого олсон, ОБЕГ-аас 0.2 сая төгрөг, тэтгэвэрт гарсан ахмад настнуудаас 1.9 сая төгрөгийн орлого олж дансанд төвлөрүүлсэн байна. Бусад байгууллагууд нь цалингийн сангаас өөр эх үүсвэрээр орлого бүрдүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэсэн заалтыг зөрчин Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар нь Төрийн банкинд 110000308146 тоот данс нээн ахмадын сангийн орлого, зардлын гүйлгээг гаргасан байна. Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д “Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газарт арилжааны банкинд байршуулсан дансыг хааж үлдэгдэл 26.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага бичигджээ. Албан шаардлагын хүрээнд 2025 онд Төрийн санд 100160031501 тоот данс нээн үлдэгдлийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр бүрэн төвлөрүүлэн ажиллажээ.

3Г-ын 2017 оны 197 дугаар тогтоолд заасан дараах арга хэмжээнд зарцуулна: Үүнд:							
№	Шалгагдагч байгууллагын нэр	Цагаан сар, ахмадын баярын арга хэмжээ	Түлш хөнгөлөлт	Эмчилгээний зардалд	Нас барсан үед олгох тэтгэмж	Аялал, амралт, спортын тэмцээн	Бусад арга хэмжээ
1	Ховд аймаг дахь ШШГГ 457 дугаар нээлттэй хаалттай хорих анги	3.0	-	-	-		
2	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	-	3.0	-	0.5	0.2	
3	Баруун бүс төв Ховд аймгийн ОБГ	11.0	-	1.1	-	1.4	2.2
4	Ховд аймаг дахь Шүүхийн газар	11.3	-	0.4	-		
5	Ховд аймгийн цагдаагийн газар	21.0	-	-	0.3		4.8
Нийт дүн		46.2	3.0	1.5	0.8	1.6	7.0

2024 онд ахмадын сангаас нийт 60.1 сая төгрөгийн зарлага гаргаж оны эцэст 77.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 3.1.2-д заасан арга хэмжээнд 46.2 сая, 3.1.3-д заасан арга хэмжээнд 3.0 сая, 3.1.6-д заасан арга хэмжээнд 1.5 сая, 3.1.7-д заасан арга хэмжээнд 0.8 сая, 3.1.8-д заасан арга хэмжээнд 1.6 сая, 3.1.9-д заасан арга хэмжээнд 7.0 сая нийт 60.1 сая төгрөгийг зарцуулжээ.